

## ГЭРИЙН ҮЙЛЧЛЭГЧ АЖИЛЛУУЛАХ ГЭРЭЭ

/Иргэд хооронд байгуулах гэрээ/

20... оны ... дугаар  
сарын .....-ны өдөр

№ \_\_\_\_\_

Улаанбаатар хот

### НЭГ. ГЭРЭЭНИЙ ТАЛУУД

1.1. Гэрийн үйлчлүүлэгч ажиллуулах гэрээ / цаашид ”Гэрээ “гэх /-г Монгол Улсын иргэн .....-ны ..... /РД: ,...../ цаашид “Ажил олгогч” гэх /, нөгөө талаас: Монгол Улсын иргэн, .....-ны ..... /РД: ..... / цаашид “Үйлчлэгч” гэх /, /хамтад нь “Талууд” гэх/ нар нь Монгол Улсын “Иргэний хууль”, Хөдөлмөрийн тухай хуулийн 69-71-р зүйл, талуудын хүсэл сонирхлыг үндэслэн үйлчлэгч нь тохиролцсон ажил, үйлчилгээг гүйцэтгэх, ажил олгогч нь гэрээний дагуу хөлс төлөхтэй холбогдох харилцааг зохицуулах зорилгоор дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

### ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 2.1. Гүйцэтгэх ажил үүрэг, байршил: Ажил олгогчийн ..... хаягт байрлах ажил олгогчийн амьдарч буй орон сууцанд дараах ажил, үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:
  - 2.1.1. Гэр цэвэрлэх,
  - 2.1.2. Хоол хүнс бэлтгэх, хийх,
  - 2.1.3. ....
- 2.2. Ажил олгогч, үйлчлэгчтэй тохиролцон ажил үүргийг тодорхой хуваарь гарган гүйцэтгүүлж болно.
- 2.3. Ажлын цалин хөлс: Нэг сарын ажлын хөлс ..... төгрөг байна.
- 2.4. Ажил, амралтын цаг: Үйлчлэгч нь 08:00 – 20:00 цагт ажил үүргээ гүйцэтгэж, 20:00 – 08:00 цагт амарч болно. Ажил үүргээ ажиллах цагтаа амжуулж хийгээгүй ажил үүргээ амралтын 20:00-22:00 цагт гүйцэтгэж болно.
- 2.5. Ажиллах хоног: Гэрийн үйлчлэгчийг 7 хоногт 1 өдөр/24 цаг/ амрах ба амралтын өдөр нь бямба, ням гарагийн аль нэг өдөр байна. Нийтээр амрах баярын өдөр үйлчлэгч зөвшөөрсөн бол нэмэлт хөлс өгч ажиллуулж болно.
- 2.6. ....

### ГУРАВ. АЖИЛ ОЛГОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Үйлчлэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, зааварчлах, үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хангуулах, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхийг шаардах бүрэн эрхтэй.
- 3.2. Үйлчлэгчид ажлын хөлсийг гэрээнд заасан хугацаанд, тохирсон хэлбэр, хэмжээгээр саадгүй төлөх үүрэгтэй.
- 3.3. ....

### ДӨРӨВ. ҮЙЛЧЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Үйлчлэгч өөрийн хувийн болон гэр бүлийн мэдээлэл, урьд эрхэлж байсан ажил үүрэг, ял шийтгэл, боловсрол, хүмүүжлийн талаарх мэдээллийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.
- 4.2. Гэрээгээр тохирсон ажлын хөлсийг авах эрхтэй.
- 4.3. Үйлчлэгч нь долоо хоногт нэг удаа тасралтгүй 24 цагаас дээш хугацаагаар амрах, ээлжийн амралт авах эрхтэй.
- 4.1. .... *Үргэлжлэл бий ...Зх*